"А" БЛОКЫН ДЭЭВРИЙН ХЭМЖИЛТИЙН БАЙГУУЛАЛТ

М1:100





ТАЙЛБАР:

"А" БЛОКЫН ДЭЭВРИЙН ХЭМЖИЛТИЙН БАЙГУУЛАЛТ

БА-10

A3

"Б,В" БЛОКЫН ДЭЭВРИЙН ХЭМЖИЛТИЙН БАЙГУУЛАЛТ

М1:100



ТАЙЛБАР:

"Б, В" БЛОКЫН ДЭЭВРИЙН ХЭМЖИЛТИЙН БАЙГУУЛАЛТ

БА-11

A3

"А" БЛОКЫН ДЭЭВРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БАЙГУУЛАЛТ

М1:100





ТАЙЛБАР:

Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх ба хар цаасыг технологийн дагуу наяж нүх сүвийг халуун битумаар сайтар бөглөх шаардлагатай.
Салхивчын яндангийн өрлөгт дулаалгын болон инженерийн арга хэмжээг авах нь зүйтэй.
Нэмэгдэл болон чулуут хар цаасыг парапет дагуулан дээш өгсүүлж парапетнаас гарсан чихэнд тулгаж наана.
Дээврийн хэсэглэлүүдийг БА-22-д үзнэ.

"А" БЛОКЫН ДЭЭВРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БАЙГУУЛАЛТ

БА-20

A3

"Б,В" БЛОКЫН ДЭЭВРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БАЙГУУЛАЛТ

М1:100



ТАЙЛБАР:

Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх ба хар цаасыг технологийн дагуу нааж нүх сүвийг халуун битумаар сайтар бөглөх шаардлагатай.
Салхивчын яндангийн өрлөгт дулаалгын болон инженерийн арга хэмжээг авах нь зүйтэй.
Нэмэгдэл болон чулуут хар цаасыг парапет дагуулан дээш өгсүүлж парапетнаас гарсан чихэнд тулгаж наана.

"Б, В" БЛОКЫН ДЭЭВРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН БАЙГУУЛАЛТ

БА-21

A3

ХЭСЭГЛЭЛ-1 М1:10



ХЭСЭГЛЭЛ -2 М1:20



ХЭСЭГЛЭЛ-3 М1:20



ХЭСЭГЛЭЛ-4 М1:20



ТАЙЛБАР

Дээвэрт ил гарах салхивчийн шахт, бохирийн хоолой зэргийг цан цохихоос хамгаалж дулаалах хэрэгтэй.
Дээвэрт гарах нэг маягийн хийц эдлэл болон бүтээцийн угсралт гүйцэтгэлийн ажлыг Г264.1-серийн альбомийг баримтлан гүйцэтгэх хэрэгтэй.

Үүнд:
а. салхивчийн шахт, бохирийн хоолой зэрэгт өмсгөх зонт
б. радио зогсоолын бэхэлгээ, хийцлэл
в. дээврийн ус зайлуулах хэсэглэл
г. парапетийн хэсэглэл, оройвч зэрэг болно.

ДЭЭВРИЙН ХЭСЭГЛЭЛҮҮД 1-4

БА-22

А3

ХЭМЖИЛТИЙН ОГТЛОЛ 1-1 М1:100



ХЭМЖИЛТИЙН ОГТЛОЛ 1-1

БА-12

A3

ХЭМЖИЛТИЙН ОГТЛОЛ 3-3 М1:100

ХЭМЖИЛТИЙН ОГТЛОЛ 2-2 М1:100



ХЭМЖИЛТИЙН ОГТЛОЛ 2-2, 3-3

БА-13

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГТЛОЛ 1-1 М1:100



·Дулаалгатай артай хулдаасан бүрээс.
·Латекс цемент-бетон зуурмаган тэгшилгээ. зузаан 30мм
·Тортой бетон. зузаан 130мм.
·Хөөсөнцөр дулаалга. зузаан 100мм.
·Ус тусгаарлагч хар цаас 3 үе.
·Бетонон дэвсгэр үе В15. зузаан 70мм.
·Элс.
·Нягтруулсан хөрс.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГТЛОЛ 1-1

БА-23

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГТЛОЛ 3-3 М1:100

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГТЛОЛ 2-2 М1:100



·Дулаалгатай артай хулдаасан бүрээс.
·Латекс цемент-бетон зуурмаган тэгшилгээ. зузаан 30мм
·Тортой бетон. зузаан 130мм.
·Хөөсөнцөр дулаалга. зузаан 100мм.
·Ус тусгаарлагч хар цаас 3 үе.
·Бетонон дэвсгэр үе В15. зузаан 70мм.
·Элс.
·Нягтруулсан хөрс.

ӨӨРЧЛӨЛТИЙН ОГТЛОЛ 2-2, 3-3

БА-24

А3

	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
1	Нүүр хуудас	БА-01
2	Зургийн жагсаалт, Тайлбар бичиг	БА-02
3	"А"блокийн дотор заслын тодорхойлолт	БА-03
4	"Б,В"блокийн дотор заслын тодорхойлолт	БА-04
5	"А"блокийн 1-р давхрын хэмжилтийн байгуулалт	БА-05
6	"А"блокийн 1-р давхрын буулгах ханын байгуулалт	БА-05*
7	"А"блокийн 2-р давхрын хэмжилтийн байгуулалт	БА-06
8	"А"блокийн 2-р давхрын буулгах ханын байгуулалт	БА-06*
9	"А"блокийн техникийн давхрын хэмжилтийн байгуулалт	БА-07
10	"Б,В"блокийн 1-р давхрын хэмжилтийн байгуулалт	БА-08
11	"Б,В"блокийн 1-р давхрын буулгах ханын байгуулалт	БА-08*
12	"Б,В"блокийн 2-р давхрын хэмжилтийн байгуулалт	БА-9
13	"А" Блокын дээврийн хэмжилтийн байгуулалт	БА-10
14	"Б,В" Блокын дээврийн хэмжилтийн байгуулалт	БА-11
15	Хэмжилтийн огтлол 1-1	БА-12
16	Хэмжилтийн огтлол 2-2, 3-3	БА-13
17	Хэмжилтийн нүүр тал 1-10	БА-14
18	Хэмжилтийн нүүр тал J-A	БА-15
19	Хэмжилтийн нүүр тал 10-1	БА-16
20	Хэмжилтийн нүүр тал A-J	БА-17
21	"А,Б,В"блокын 1-р давхрын өөрчлөлтийн байгуулалт	БА-18
22	"А,Б,В"блокын 2-р давхрын өөрчлөлтийн байгуулалт	БА-19
23	"А" Блокын техникийн давхрын байгуулалт	БА-19*
24	"А" Блокын дээврийн өөрчлөлтийн байгуулалт	БА-20
25	"Б,В" Блокын дээврийн өөрчлөлтийн байгуулалт	БА-21
26	Дээврийн хэсэглэлүүд 1-4	БА-22
27	Өөрчлөлтийн огтлол 1-1	БА-23
28	Өөрчлөлтийн огтлол 2-2, 3-3	БА-24
29	Өөрчлөлтийн нүүр тал 1-10	БА-25
30	Өөрчлөлтийн нүүр тал J-A	БА-26
31	Өөрчлөлтийн нүүр тал 10-1	БА-27
32	Өөрчлөлтийн нүүр тал A-J	БА-28
33	Хэсэгчилсэн байгуулалт - 1	БА-29
34	Хэсэгчилсэн байгуулалт - 2	БА-30
35	Хэсэгчилсэн байгуулалт - 3, 4	БА-31
36	Гадна довжоо ГД-1, Огтлол 1-1, 2-2	БА-32
37	Гадна довжоо ГД-2, ГД-3, Огтлол 1-1, 2-2	БА-33
38	"А"блокийн 1-р давхрын шалны байгуулалт	БА-34
39	"А"блокийн 2-р давхрын шалны байгуулалт	БА-35
40	"Б,В"блокийн 1-р давхрын шалны байгуулалт	БА-36
41	"Б,В"блокийн 2-р давхрын шалны байгуулалт	БА-37
42	1, 2-р давхрын шалны бүтэц	БА-38
43	Цонхны зураг түүвэр	БА-39
44	Хаалганы зураг түүвэр	БА-40
45	Метал сайдингийн хэсэглэл-1,2	БА-41
46	Метал сайдингийн хэсэглэл-3,4	БА-42
47	Метал сайдингийн хэсэглэл-5,6	БА-43
	ТЕХНОГИЙН ХЭСЭГ	
48	"А"блокийн 1-р давхрын технологийн байгуулалт	ТХ-1
49	"А"блокийн 2-р давхрын технологийн байгуулалт	ТХ-2
50	"Б,В"блокийн 1-р давхрын технологийн байгуулалт	ТХ-3
51	"Б,В"блокийн 2-р давхрын технологийн байгуулалт	ТХ-4

ЗУРГИЙН ШАГСААЛТ, ТАЙЛБАР БИЧИГ

ЕРӨНХИЙ ХЭСЭГ:
Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах одоо байгаа 4-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлын зураг төслийг аймаг, орон нутгийн захиалга, 2024 оны ,,-р сарын ,,-ны өдрийн ,,,,,,, тоот зураг төсөл боловсруулах даалгаврыг үндэслэн Барилгын зураг, төсвийн "Шигота" ХХК-д боловсруулав.

БАРИЛГА АРХИТЕКТУР:
Уг барилга нь 1983 онд баталгаасан нэг маягийн зураг төсөлтэй, 1987 онд бариагдаж ашиглалтанд орсон. Тус цэцэрдэгийн барилга нь тэнхлэгээрээ 12.00м х 36.80м харьцаатай 2 давхар, 6.00м х 15.00м харьцаатай 2 давхар, 12.00м х 12.20м харьцаатай 1 давхар хавтгай дээвэртэй, даацын тоосгон ханатай 3 блок барилга болно.
Ашиглалтанд орсноос хойш 2005 онд дээврийн хэсэгчилсэн засвар, 2013 онд цонх болон халаалтын шугам сүлжээг солих засвар хийгдсэн бөгөөд өөр их засвар хийгдэж байгаагүй, дээврээс борооны ус нэвчдэг, инженерийн шугам сүлжээ бүхэлдээ доголдож хагарсан ашиглалтын явцад хүндрэлтэй болсон тул барилгын дотор иж бүрэн засвар хийж, гадна өнгөлгөөнд метал сайдинг хийхээр төлөвлөв.

Хана:
"А, Б, В" блокын гадна хана 640мм зузаантай тоосго, дотор хана 380мм, 120мм зузаантай тоосгон ханатай.

Хучилт:
"А, Б, В" блок нь угсармал төмөр бетон хучилттай.
Дээвэр: Хавтгай хуйлмал хар цаасан дээвэртэй.

Ерөнхий зүйл:
Барилгын засварын ажлыг гүйцэтгэх явцад холбогдон гарах бусад жижиг засварын ажлуудыг захиалагч ашиглагч гүйцэтгэгч зохиогч талуud харилцан зөвшөөрөлцөн газар дээр нь тохируулан гүйэтгэнэ. Барилгын засвар, өөрчлөлт, угсралтын ажлыг гүйцэтгэх явцад гүйцэтгэгч байгууллага нь захиалагч болон ашиглагч байгууллагын саналыг тухай бүр сонсож асуудлыг захиалагч, ашиглагч байгууллагууд болон зохиогчтой хамтран шийдвэрлэж байх хэрэгтэй.

Хийгдэх засвар:

Шал:
1-р давхрын одоо байгаа банзан шалыг буулгаж шугам явж буй сувгийг үлдээн бусд хэсгээр булаалгатай бетон шал цутгаж хийхээр төлөвлөв / огтлолоос шалны бүтцийг харна уу / гал тогоо болон бүх ариун цэврийн өрөөний одоо байгаа вааран хавтан өнгөлгөөг хуулж шинээр халтирдаггүй барзгар гадаргуутай вааран хавтангаар шаллах бөгөөд шаланд ус тусгаарлагч 1 үе гидриозолийг дэвсэж ханалуу 300мм цоройлгон нааж өгнө. Вааран хавтангын өнгө загварыг зурагт заасны дагуу сонгох ба захиалагчийн хүсэлтээр өөрчлөх тохиолдолд зохиогчтой зөвшилцөнө.
Бусд өрөө тасалгаанд сургууль цэцэрлэгийн зориулалттай дулаалга, дуу тусгаарлагчтай сайн чанарын хулдаасаар шаллана. Шалны хулдаасыг ханалуу 100мм цоройлгон нааж хулдаасан шалны зориулалтын хүрээгээр шалны хөвөө хийнэ.

Хана:
Зурагт заасан 120мм-ийн зузаантай даацын бус тоосгон ханануудыг буулган өрөөг зай талбай ихтэй байхаар төлөвлөв. Үүнд: Аяганы өрөө /буфет/, ариун цэврийн өрөөнүүд, гал тогооны өрөө багтана.
Гал тогооны өрөөний да ариун цэврийн өрөөнүүдийн одоо байгаа хананы гадаргуу дахь хуучин будгийг сайтар хусаж цэвэрлэх, хэсэгчилэн наасан вааран хавтанг буулган хананы гадаргууд тэгшилгээ шавардлага хийж замаска тавих ба шалнаас дээш 1,80м түвшин хүртэл вааран хавтан өнгөлгөө хийнэ вааран хавтан өнгөлгөөнөөс дээш буюу шалны түвшнээс дээш 2,95м хүртэл 2 үе тосон будагаар будана. /будаг нь сургууль цэцэрлэгийн зориулалттай, эрүүл ахуйн шаардлага хангасан, цайвар өнгийн байна/
Таазнаас доош 5см хэмжээтэй хүрээ үлдэнэ.

Тааз:
Нийт өрөө тасалгаа коридорын таазанд замаск тэгшилгээ хийж, цагаан өнгийн эмульсэн будгаар 2уе тус тус будна. Заслын ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөр хамгаалал болон чанар үзэмжид анхаарч цэвэр нямбай гүйцэтгэх.

Дээвэр:
Одоо байгаа дээврийн дулаалгын материалыг хучилтын хавтан хүртэл буулгаж, хучилтын гадаргууг сайтар цэвэрлэн шинээр дулаалах тул дээврийн бүтцийг огтлолын зургаас харна уу. Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай ба дээврийн ажил гүйцэтгэх стандартыг бариимтлан хийж гүйцэтгэнэ.

Цонх, хаалга:
Одоо байгаа цонх болон хаалгыг иж бүрэн буулгаж шинээр солих бөгөөд цонх нь 3 давхар шиллэгээтэй цагаан өнгийн хуванцар жаазтай байна. Хаалга нь сургууль цэцэрлэгийн зориулалттай хязгаарлагчтай цайвар өнгийн модон хаалга байхаар төлөвлөв. Цонх хаалганы түүврээс үзнэ үү. Цонх болон хаалгын заслын ажил дууссаны дараа газар дээрээс нарийвчилсан хэмжээг дахин авч захиалах ба цонх, хаалга нь томдох, жижигдэх асуудлыг зургийн байгууллага хариуцахгүй болно.

Бусад:
Барилгын ажлын явцад ойлгомжгүй зөрчилдөх зүйл илрэх тохиолдолд цаг тухай бүрт нь зохиогч байгууллагад мэдэгдэж байх ёстой. **МӨН БАРИЛГЫН БЛОК ХООРОНДЫН ШОВНЫ ЗАЙ ЗАВСАРЫГ ЧУЛУУ ХӨВӨНГӨӨР САЙТАР ЧИГЖИН ДУЛААЛСАНЫ ДАРАА ГАДНА ФАСАД БОЛОН ДЭЭВРИЙН АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ШААРДЛАГАТАЙ !!!**

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ АЮУЛГҮЙ БАЙДАЛ:
Барилга угсралтын явцад /БНбД 12-03047/, Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм, /БНбД 12-101-05/, Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн дүрмүүдийг чанд сахин ажиллахын зэрэгцээ барилгын угсралтын үед ашиглах түр хашаа, хамгаалалт, ус зайлуулалт, тоосжилтоос хамгаалсан хамгаалалт, аваар ослоос сэргийлэх арга хэмжээний асуудлыг шийдсэн байх.

ЗАХИАЛАГЧИ ТАЛ:
Захиалагч нь барилгын талбай дээр өөрийн талын мэргэжлийн төлөөлөгчийг ажиллуулах бөгөөд тухайн мэргэжилтэн нь угсралтын ажилд тогтмол хяналт тавина.
Жич: Энэхүү зураг төслийн баримт бичиг нь зохиогчийн эрхийн тухай хуулиар хамгаалагдах тул зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин ашиглахыг хориглоно.

Барилгын их засвар, өөрчлөлт, угсралтын ажлыг доорх Барилгын норм да дүрэм БНбД-ийн дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй.